

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арав дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/94/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж  
Утас: 77721628  
Цахим хаяг: [Byambadorj@growthfinance.mn](mailto:Byambadorj@growthfinance.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 51

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН ХҮҮХДИЙН 10 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Н.ӨНӨРЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын аравдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 729,893.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 672,075.5 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>122,491,743.65</u></b>	<b><u>44,472,398.01</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	56,712,709.65	5,262,944.01
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	56,712,709.65	5,262,944.01
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	56,712,709.65	5,262,944.01
31211	Төрийн сангийн харилцах	56,712,709.65	5,262,944.01
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,779,034.00	39,209,454.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	107,200.00	-
35130	Эм боох материал	107,200.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	65,671,834.00	39,209,454.00
35410	Бичиг хэргийн материал	231,100.00	165,000.00
35420	Аж ахуйн материал	40,927,734.00	34,195,454.00
35450	Барилгын засварын материал	24,513,000.00	4,849,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>108,642,714.35</u></b>	<b><u>100,181,328.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	108,642,714.35	100,181,328.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	78,342,714.35	69,881,328.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,941,159.50	98,591,159.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,065,542.45)	(54,186,234.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,323,938.00	40,493,713.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,305,840.70)	(16,521,309.17)
39217	Ном	1,449,000.00	1,504,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	30,300,000.00	30,300,000.00
39301	Програм хангамж	2,200,000.00	2,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,900,000.00)	(1,900,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>231,134,458.00</u></b>	<b><u>144,653,726.91</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>5,255,281.07</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	5,255,281.07
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	5,255,281.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,177,281.07
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,078,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>231,134,458.00</u></b>	<b><u>139,398,445.84</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	231,134,458.00	139,398,445.84
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	231,134,458.00	139,398,445.84
51210	Өмнөх үеийн үр дүн	231,134,458.00	231,134,458.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(91,736,012.16)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>231,134,458.00</u></b>	<b><u>144,653,726.91</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>735,255,877.00</b>	<b>692,786,925.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>55,016,977.00</b>	<b>20,886,425.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	55,016,977.00	10,716,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,800,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,800,000.00	175,000.00
<b>122</b>	<b>Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө</b>	-	10,169,775.00
122001	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	-	10,541,650.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>680,238,900.00</b>	<b>671,900,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	587,783,900.00	625,060,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,783,900.00	625,060,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	92,455,000.00	46,840,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,455,000.00	46,840,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>679,498,064.27</b>	<b>784,522,937.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>679,498,064.27</b>	<b>784,522,937.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	647,051,058.77	771,701,331.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	460,387,887.58	540,265,057.41
210101	Үндсэн цалин	331,834,994.79	363,781,850.07
210102	Нэмэгдэл	109,780,479.53	137,973,296.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,170,000.00
210104	Урамшуулал	18,772,413.26	22,339,911.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,835,557.35	66,071,299.30
210201	Тэтгэврийн даатгал	35,848,375.06	45,018,315.99
210202	Тэтгэмжийн даатгал	4,254,027.54	5,351,872.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,437.95	2,649,391.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,208,611.71	2,622,283.84
210205	Эрүүл мэндийн даатгал	8,380,105.09	10,429,435.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,232,794.50	27,518,694.70
210301	Гэрэл, цахилгаан	4,862,488.00	5,608,584.00
210302	Түлш, халаалт	32,732,660.00	19,426,176.00
210303	Цэвэр, бохир ус	4,637,646.50	2,483,934.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	10,541,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	10,541,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	54,384,000.00	55,617,440.00
210502	Хоол, хүнс	54,384,000.00	55,617,440.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,517,000.00	26,164,000.00
210604	Урсгал засвар	3,517,000.00	26,164,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,950,000.00	1,517,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,950,000.00	1,517,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	31,743,819.34	44,005,390.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,549,790.00	19,517,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,625,100.00	5,151,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,568,929.34	19,336,160.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,447,005.50	12,821,605.30
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,224,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,224,800.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	24,222,205.50	12,821,605.30
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг- Хөрөнгийн	24,222,205.50	12,821,605.30

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арав дугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>55,757,812.73</b>	<b>(91,736,012.16)</b>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>55,757,812.73</b>	<b>(91,736,012.16)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>698,038,900.00</b>	<b>672,075,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,800,000.00</b>	<b>175,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,800,000.00	175,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	17,800,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,800,000.00	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>680,238,900.00</b>	<b>671,900,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	587,783,900.00	625,060,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,783,900.00	625,060,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	92,455,000.00	46,840,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,455,000.00	46,840,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>684,284,334.93</b>	<b>722,820,265.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>684,284,334.93</b>	<b>722,820,265.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>651,837,329.43</b>	<b>709,998,660.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	460,387,887.58	536,087,776.34
210101	Үндсэн цалин	331,834,994.79	359,604,569.00
210102	Нэмэгдэл	109,780,479.53	137,973,296.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,170,000.00
210104	Урамшуулал	18,772,413.26	22,339,911.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,835,557.35	66,071,299.30
210201	Тэтгэврийн даатгал	35,848,375.06	45,018,315.99
210202	Тэтгэмжийн даатгал	4,254,027.54	5,351,872.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,437.95	2,649,391.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,208,611.71	2,622,283.84
210205	Эрүүл мэндийн даатгал	8,380,105.09	10,429,435.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,232,794.50	27,518,694.70
210301	Гэрэл, цахилгаан	4,862,488.00	5,608,584.00
210302	Түлш, халаалт	32,732,660.00	19,426,176.00
210303	Цэвэр, бохир ус	4,637,646.50	2,483,934.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	54,384,000.00	54,539,440.00
210502	Хоол, хүнс	54,384,000.00	54,539,440.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,000,000.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	26,000,000.00	6,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,950,000.00	3,237,510.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,950,000.00	3,237,510.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,047,090.00	16,043,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,061,990.00	10,830,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,985,100.00	5,213,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,447,005.50</b>	<b>12,821,605.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,224,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,224,800.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арав дугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	24,222,205.50	12,821,605.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,222,205.50	12,821,605.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,754,565.07</u></b>	<b><u>(50,744,765.64)</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>25,776,705.00</b>	<b>705,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,776,705.00</b>	<b>705,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	25,776,705.00	705,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,776,705.00	705,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(25,776,705.00)</u></b>	<b><u>(705,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(12,022,139.93)</b>	<b>(51,449,765.64)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>68,734,849.58</b>	<b>56,712,709.65</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>56,712,709.65</b>	<b>5,262,944.01</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>175,376,645.27</b>	<b>175,376,645.27</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	175,376,645.27	175,376,645.27
Тайлант үеийн үр дүн	-	-	55,757,812.73	55,757,812.73
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>231,134,458.00</b>	<b>231,134,458.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	231,134,458.00	231,134,458.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(296,600.00)	296,600.00	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(91,736,012.16)	(91,736,012.16)
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	<b>(296,600.00)</b>	<b>139,695,045.84</b>	<b>139,398,445.84</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Данс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2</b>	<b>729,893,200.00</b>	<b>710,703,660.34</b>	<b>19,189,539.66</b>	<b>97.37</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21</b>	<b>729,893,200.00</b>	<b>710,703,660.34</b>	<b>19,189,539.66</b>	<b>97.37</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>210</b>	<b>729,893,200.00</b>	<b>710,703,660.34</b>	<b>19,189,539.66</b>	<b>97.37</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2101	537,684,100.00	536,087,776.34	1,596,323.66	99.7
Үндсэн цалин	210101	362,898,400.00	359,604,569.00	3,293,831.00	99.09
Нэмэгдэл	210102	158,969,100.00	137,973,296.34	20,995,803.66	86.79
Унаа, болон бусад нөхөн олговор	210103	-	16,170,000.00	(16,170,000.00)	-
Урамшуулал	210104	15,816,600.00	22,339,911.00	(6,523,311.00)	41.24
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2102</b>	<b>66,854,100.00</b>	<b>66,071,299.30</b>	<b>782,800.70</b>	<b>98.83</b>
Тэтгэврийн даатгал	210201	45,346,800.00	45,018,315.99	328,484.01	99.28
Тэтгэмжийн даатгал	210202	5,376,900.00	5,351,872.12	25,027.88	99.53
ҮОМШӨ ний даатгал	210203	2,688,400.00	2,649,391.98	39,008.02	98.55
Ажилгүйдлийн даатгал	210204	2,688,400.00	2,622,283.84	66,116.16	97.54
Эрүүл мэндийн даатгал	210205	10,753,600.00	10,429,435.37	324,164.63	96.99
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2103</b>	<b>40,340,300.00</b>	<b>27,518,694.70</b>	<b>12,821,605.30</b>	<b>68.22</b>
Гэрэл цахилгаан	210301	10,584,300.00	5,608,584.00	4,975,716.00	52.99
Түлш, халаалт	210302	19,426,200.00	19,426,176.00	24.00	100
Цэвэр, бохир ус	210303	10,329,800.00	2,483,934.70	7,845,865.30	24.05
<b>Нормативт зардал</b>	<b>2105</b>	<b>58,438,600.00</b>	<b>54,539,440.00</b>	<b>3,899,160.00</b>	<b>93.33</b>
Хоол, хүнс	210502	58,438,600.00	54,539,440.00	3,899,160.00	93.33
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>2106</b>	<b>6,500,000.00</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>	<b>100</b>
Урсгал засвар	210604	6,500,000.00	6,500,000.00	-	100
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>2108</b>	<b>3,240,200.00</b>	<b>3,237,510.00</b>	<b>2,690.00</b>	<b>99.92</b>
Мэдээллийн технологийн зардал	210806	3,240,200.00	3,237,510.00	2,690.00	99.92
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2201</b>	<b>16,835,900.00</b>	<b>16,748,940.00</b>	<b>86,960.00</b>	<b>99.48</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	11,622,100.00	11,535,140.00	86,960.00	99.25
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210902	5,213,800.00	5,213,800.00	-	100
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>729,893,200.00</b>	<b>659,253,894.70</b>	<b>57,817,700.00</b>	<b>92.08</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1310</b>	<b>629,131,900.00</b>	<b>625,060,200.00</b>	<b>4,071,700.00</b>	<b>99.35</b>
Улсын төсвөөс санхүүжих	131001	629,131,900.00	625,060,200.00	4,071,700.00	99.35
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1320</b>	<b>46,840,300.00</b>	<b>34,018,694.70</b>	<b>-</b>	<b>100</b>
Орон нутгийн төсвөөс	132001	46,840,300.00	34,018,694.70	-	100
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>120004</b>	<b>53,921,000.00</b>	<b>175,000.00</b>	<b>53,746,000.00</b>	<b>0.32</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200041	418,000.00	-	418,000.00	-

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арав дугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	-	175,000.00	(175,000.00)	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1200043	53,503,000.00	-	53,503,000.00	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4</b>	<b>56,712,709.65</b>	<b>56,712,709.65</b>	<b>(56,712,709.65)</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5</b>	<b>56,712,709.65</b>	<b>5,262,944.01</b>	<b>(5,262,944.01)</b>	<b>-</b>
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6	1	1	-	100
БАЙГУУЛЛАГЫН ТОО	61	1	1	-	100
АЖИЛЛАГСДЫН ТОО	62	20	20	-	100
Удирдах ажилтан	620001	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	620002	8	8	-	100
Үйлчлэх ажилтан	620003	11	11	-	100

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 17,815.4 мянган төгрөгийн 1 алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- Үндсэн хөрөнгийн тайлангийн орлого, зарлага, үлдэгдлийг харгалзах ерөнхий дэвтрийн дансны дебет, кредит болон үлдэгдэлтэй тулган шалгахад хуримтлагдсан элэгдэл 17,870.4 мянган төгрөгөөр дутуу, номын өртөг 55.0 мянган төгрөгөөр дутуу, эцсийн үлдэгдэл нийт 17,815.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Аудитаар залруулаагүй 8,002.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2,664.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5,338.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 2,664.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 8,253.5 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### **3.1 Албан шаардлага**

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.22-ны өдрийн Б/18 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр гэсэн үндэслэлээр "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Татварын өр төлбөрийн талаар

*Илрүүлэлт:* Архангай аймгийн татварын албанд ажилчдын цалин хөлснөөс суутгасан 2025 оны 12 дугаар сарын хувь хүний орлогын албан татварын 4,177.3 мянган төгрөгийг төлөөгүйн улмаас санхүүгийн тайланд өр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.6.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ. гэснийг мөрдөөгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажиллагсдын цалин хөлснөөс суутган тооцсон хувь хүний орлогын албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төсөвт шилжүүлж байх зөвлөмж хүргүүлэх.

#### 3.2.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу тайлагнал

*Илрүүлэлт:* Цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад нэр бүхий 5 ажилтны цалинг 113.2 мянган төгрөгөөр илүү, 1,048.4 мянган төгрөгөөр дутуу нийт 1,161.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж 224.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тайлагнаж төлсөн алдаа байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэсэн заалтыг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 заалтыг ханган ажиллах,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөтэй холбоотой	1	17,815.4					1	17,815.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,815.4</b>					<b>1</b>	<b>17,815.4</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын өрийг хугацаанд нь төлөөгүй байна.	1	4,177.3					1	4,177.3
Нийгмийн даатгалын тайланд цалингийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	1,161.6					1	1,161.6
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>8,002.9</b>			<b>1</b>	<b>2,664.0</b>	<b>2</b>	<b>5,338.9</b>